



Model APS-57E

Гарын авлага

3 сувагтай алсаас асаагч

ҮЗҮҮЛЭЛТҮҮД :

Програмчлах боломжтой 3 товчлууртай 2 удирдлага

3 сувгийн хүлээн авагч (4 хүртэлх удирдлага хүлээж авна)

LED гэрэл, товчлууртай, Superheterodyne хүлээн авагч антентай

Алсаас машин асаана

Алсаас багааж онгойлгоно

Машин асаах автомат релей

Өөртөө програмчлал, функцийн боломжтой

Оврын гэрлээр дохио өгөх функц

Дохиог тэмдэглэх


Асаагүй үед дохио/анхааруулга өгөх

Ассаныг илтгэж оврын гэрэл асаах эсвэл анивчуулах сонголт

Асаах хугацаа: 5, 10, 15, 20, 45, 60 минут

Хаалга түгжих хугацааг тохируулна

Машин хайх горимтой



PATENTED: www.voxintl.com/company/patents

128-9311

1 of 4

Удирдлагаар нээх

Удирдлага дээр байрлах LOCK болон UNLOCK товчнууд нь автомашины хаалгыг түргийн ба онгойлгоход ашиглагдана. Зөвхөн нэг удаа дарахад хангалттай. Хаалга түргийгдэх үед дохионы гэрэл нэг удаа, онгойход дохионы гэрэл хоёр удаа анивчина.

Машинаа хайх

LOCK ба UNLOCK товчнуудаар “машин хайх” горимыг идэвхжүүлэх боломжтой. Энэхүү горим нь олон машинтай зогсоолоос машинаа хайж олоход тохиромжтой. Хайлтын горимыг ажиллуулахдаа удирдлаганыхаа Lock болон Unlock товчны аль нэгийг 3 орчим секунд дарна. Ингэхэд машины оврын гэрэл 30 секундийн турш автоматаар анивчиж олоход хялбар болно. Хэрэв та 30 секундээс өмнө машинаа олсон бол Lock болон Unlock товчны аль нэгийг дахин дарахад гэрэл анивчихаа болино.

Багааж нээх

Хэрэв таны машины багааж автомат ажиллагаатай бол энэхүү горимыг ашиглах боломжтой. Удирдлаганы “Key” товчийг 4 секундийн турш дарснаар багааж автоматаар онгойно.

МАШИН АСААХ ГОРИМ

Дараах асуудлуудын аль нэг нь байвал асаах горим ажиллахгүй. Үүнд:

- Машины капот онгорхой байх
- Араа солих сонголт P буюу parking горимд шилжээгүй
- Тоормос гишгээтэй үед
- Аюулгүй ажиллагааны хяналтын унтраалга “Off” горимд байх үед

1. Удирдлагаар машиныг асаахын тулд “ТҮЛХҮҮРТЭЙ товчлуур” дээр 2 удаа (2 секундийн дотор) дарна. Машин урьдчилан програмчлагдсаны дагуу 5, 10, 15, 20, 45 болон 60 минут хүртэлх циклээр ажиллана. Тохиргоог хэрхэн хийснээс шалтгаалж машины ассан эсэхийг оврын гэрэл асах юмуу анивчиж мэдэгдэнэ.

2. Та машин дээрээ очсоны дараа түлхүүрээ хийн START дээр тавина. (Машиныг асаах гэж түлхүүр дарах шаардлагагүй) Асаалтын горимоос салгахын тулд тоормос дээр гишгээрэй. Ингэснээр машин асаалтын системээс салж хэвийн горимд шилжинэ.

Тайлбар Дараах тохиолдлуудад машины хөдөлгүүр өөрөө унтрахыг санаарай. Үүнд:

- Удирдлаганыхаа “ТҮЛХҮҮРТЭЙ товчийг” дахин 2 удаа (2 секундын дотор) дарах
- Тоормос дээр гишгэсэн тохиолдолд
- Капот нээлттэй тохиолдолд
- Safety удирдлагыг Disabled буюу идэвхгүй горимд тавьсан

Led-тэй товчийг дарж идэвхгүй болгох

Алсаас асаах функцийг идэвхгүй болгохыг хүсвэл удирдлага дээрх Товчтой Led-ийг дараарай. Засвар үйлчилгээнд орж байхад энэ үйлдлийг заавал хийгээрэй.

АНХААРУУЛГА: УДИРДЛАГЫГ СУУРИЛУУЛАХ ҮЕД ХУГАЦААГ ТАНЫ
ХҮССЭНЭЭР ТОХИРУУЛЖ ӨГНӨ. ХЭРВЭЭ ХУГАЦААГ ӨӨРЧЛӨХ
ШААРДЛАГАТАЙ БОЛ ДООРХ ЗААВРЫН ДАГУУ ТОХИРУУЛНА.
БУСАД АЛИВАА ТОХИРГООГ МЭРГЭЖЛИЙН ТӨВД ХАНДАН ХИЙЛГЭЭРЭЙ!

МАШИНЫ АСАЛТЫН ХУГАЦААГ ТОХИРУУЛАХЫН ТУЛД

1. Машины түлхүүрийг ON дээр тавина.
2. "VALET/PROGRAMMING" товч дээр 3 удаа дарна. (Дуут дохио 1 удаа дуугарна.)
3. Машины түлхүүрийг OFF болгоод дахиад ON болгоно. (Дуут дохио 2 удаа дуугарна.)
4. Машины түлхүүрийг дахин OFF болгоод буцаагаад ON болгоно. (Дуут дохио 3 удаа дуугарна.)
5. Хүлээн авагч антенний товчлуур дээр 3 удаа дарна.
LOCK товчлуур дээр дарахад дуут дохио 1 удаа дуугарвал 5 минут асахаар тохируулагдана. LOCK товч дээр дахин дарахад дуут дохио 2 удаа дуугарч байвал 10 минут асахаар тохируулагдана. Энэ мэт өөрийн хүссэн хугацааг доорх хүснэгтийн дагуу сонгоно.

1 дуут дохио	5 мин
2 дуут дохио	10 мин
3 дуут дохио	15 мин
4 дуут дохио	20 мин
5 дуут дохио	45 мин
6 дуут дохио	60 мин
6. Харгалзах дуут дохиог сонгон LOCK товч дээр дарж хугацааг сонгоно.
7. Тохиргооны горимоос гарахын тулд түлхүүрээ OFF болгож 6-с олон секунд хүлээнэ Богиноор нэг дохио өгч, үргэлжлүүлэн урт дохио өгч тохиргооны горимоос гарсныг мэдэгдэнэ.

Системд бүртгэлтэй удирдлагын анхааруулга (PTN)

Машинаа асаах бүрт системд бүртгэлтэй удирдлагын тоог LED гэрэл анивчиж мэдээлдэг. Энэ нь асаалтын системд үл мэдэгдэх гадны удирдлага холбогдсон эсэхийг анхааруулах зориулалттай юм. Үйлдвэрээс ихэвчлэн системд 2 удирдлага холбогдсоныг илтгэхдээ LED гэрэл 3 удаагийн давтамжтайгаар 2 удаа анивчихаар тохируулсан байдаг. Хэрэв гэрэл илүү олон анивчихыг анзаарвал таны системд 2-оос илүү удирдлага холбогдсоныг анхааруулж буй дохио юм. Энэ тохиолдолд сервис төвд хандан дахин програмчлуулж зөвшөөрөлгүй удирдлагыг системээсээ устгуулаарай.

Удирдлагын батерей солих

1. Удирдлаганы арын тагны "00" цэгийн эргийг тайлж авах
2. Болгоомжтойгоор урд хэсгийг ард талаас салгаж авах
3. CR2032 батерейг хавчаараар авч хаях, шинэ батерейг хийх
4. Тагийг буцааж хаана.

Суурилуулах ажиллагаа _____
Суурилуулсан инженер бөглөнө _____

Асах хугацаа _____
Хаалга түгжих хугацаа _____
Гэрэл _____

_____ Мин
_____ Сек
Анивчих Тогтмол

FCC Compliance

Энэ төхөөрөмж нь FCC дүрмийн 15-р хэсэгт тохирсон заалттай. Бас Канадын үйлдвэрлэлийн RSS-210 стандартыг хангасан.

Дараах нөхцөлийг хангана.

1. Автомашин бусад хэсэгт нөлөөлөх ямар нэгэн үйлдэлгүй.
2. Өөр төхөөрөмжийн сигналыг хүлээж авахгүй.

Анхаар!

Төхөөрөмжийн ажиллагааг өөрчлөх, хөдөлгөх нь ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй. Төхөөрөмж барагтай өөрчлөлтөд тэсвэртэй ч үүнийг анхаарч байхад илүүдэхгүй.

Сануулах нь: Энэ төхөөрөмжийг өөрчилсөн, бусад хүчтэй радио сигналын улмаас ажиллагаа нь доголдох үед үүсэх үр дагаврыг үйлдвэрлэгч хариуцахгүй.

Удирдлагыг солих болон өөр нэмэлт төхөөрөмж худалдаж авахыг хүсвэл www.prestigecarsecurity.com

© 2014 Voxx Electronics Corp., 150 Marcus Blvd., Hauppauge, NY 11788

128-9311